

**“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК
БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН**



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
“ДАРХАН ЭРДЭС ШОХОЙТ ШИИР” ХХК-ИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Дархан-Уул аймаг
2025 он

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

1. КОМПАНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
2. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	9
3.1 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
3.2 ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
3.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ	
3.4 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНОО ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	
3.5 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	
4. БОМТ-ИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮГНЭЛТ.....	27
5. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН БОЛОН БУСАД ХАВСРАЛТУУД ХАВСРАЛТ	

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Зургийн жагсаалт

- Зураг №1 Шохийн чулууг бутлах бутлуур
Зураг №2. Шохийн чулуу тээрэмдэх тээрэм
Зураг №3 Шохийн чулуу үйлдвэрлэх технологийн бүдүүвч зураг
Зураг №4 Өнгөлгөөний замаск үйлдвэрлэх технологийн бүдүүвч
Зураг №5 Шохийн чулууг бутлах тээрэмдэх үйлдвэрийн тойм зураг
Зураг №6 Үйлдвэрлэлийн Google map.c авсан тойм зураг
Зураг №7-8 Үйлдвэрийн хашаанаас 30 метр зайдхашаа татаж мод тарих талбай бэлтгэсэн байдал
Зураг №9-10 Талбайд мод тарихаар шан татаж байгаа байдал
Зураг №11-12 2-3 настай модны суулгац
Зураг №13-14 Модны суулгацаа тарихаас өмнө бордоо хийж байна.
Зураг №15-16 Модоо тариад намрын цээг усалгааг хийж байна. /гадаа агаарын температур +5°C/
Зураг №17-18 Модны нүх бэлдсэн байдал
Зураг №19-20 7-рсард модны суулгац бүрэн ургасан байдал
Зураг №30 Ургасан байдал
Зураг №31 Үйлдвэрийн хашаанаас 500 метр хог хаягдлыг түүж ачиж хаясан.
Зураг №32-33 Замын хажууд хогийн хаясан байсан түүж ачиж байна
Зураг №33-34 Тархсан хог хаягдалыг түүж байна
Зураг №35-36 Түүсэн хогоо хогийн цэг рүү тээвэрлэж байна.
Зураг №37-38 Эх байгалиа хайрлацгаая гэсэн санамж байршуулсан.
Зураг №39 хяналтын цэгийн байдал
Зураг №40 БОШ-ий хяналт шинжилгээ хийх дараалал
Зураг №41-42 Агаарын шинжилгээг авч байна
Зураг №43-44 Үйлдвэрийн орчинд Хөрсний хэмжилт хийж буй хэсэг
Хүснэгт №1 Байршлын солбицол
Хүснэгт №2 Гол болон сөрөг нөлөөллийн үнэлгээний шалгуур ба анхаарвал зохих асуудлууд
Хүснэгт №3 Төслийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ
Хүснэгт №4 Хог хаягдлын тухай сургалтын төлөвлөгөө
Хүснэгт №5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга замын авах арга хэмжээ
Хүснэгт №6 Тоосжилтийг хянах
Хүснэгт №7 Хөрсний химийн үзүүлэлт
Хүснэгт №8 Байгаль орчныг тухайн жилд байгаль хамгаалах менежмент төлөвлөгөөний төсвийн зардлын биелэлт
Хавсралт №1 Тусгай зөвшөөрөл
Хавсралт №2 Мод тарих гэрээний хүснэгтээс
Хавсралт №3 2025 оны БОМТ-ны батлагдсан нүүр хэсэг
Хавсралт №4 Агаарын шинжилгээний нэг хэсэг тоосны дүн
Хавсралт №5 Хөрсний шинжилгээний дүн
Хавсралт №6 Агаарын шинжилгээний бохирдлын дүн

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН НЭР

“Барилгын материал үйлдвэрлэл”

1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Шийрийн хөндийн адагт Цохио Толгойн шохойн чулууны 2-р ордод байрлалтай “Идэр Хайрхан” ХХК-ийн Шохойн чулууны ордоос үйлдвэрийн түүхий эдээ авч, тээрэмдэж байгаль орчинд халгүй технологоор үйлдвэрлэлээ явуулахад төслийн гол зорилго оршино.

1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НЭР

“Дархан Эрдэс Шохойт Шийр” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 1911017100

Регистрийн дугаар: 4264959

1.4 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ

Дархан-Уул аймаг, Дархан сум 8-р баг 12-63 тоот

1.5 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Дархан уул аймгийн Хонгор сумын Шийрийн хөндийд 3 га талбай бүхий газар, Дархан хотоос зүүн хойд зүгт 8км зайд байрладаг

Хүснэгт №1 Байршлын солбицол:

№	Х	У	Урт
1	574555.44	5476478.48	164.27
2	574583.24	5476640.32	164.95
3	574734.33	5476574.28	166.52
4	574822.17	5476432.87	270.69

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарыг Дархан-Уул аймгийн Төмөрлөгийн үйлдвэр болон Улаанбаатар хотын Барилга архитектур корпораци итгэмжлэгдсэн лаборатороор тодорхойлуулан ажилладаг болно.

Шохой, магни /эрдэс, замаск/ гөлтгөнө болон холимог барьцалдуулагч бүхий барилгын материалыг үйлдвэрлэн хүргэж байна.

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

ШОХОЙН ЧУЛУУ ТЭЭРЭМДЭХ



Зураг №1 Шохиойн чулууг бутлах бутлуур



Зураг №2. Шохойн чулуу тээрэмдэх тээрэм

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН


а) Үйлдвэрийн танилцуулга

- “ДЭШШ” ХХК нь 2013 онд байгуулагдсан бөгөөд 2017 оноос эхлэн Хонгор сумын Шийрийн хөндийд үйл ажиллагаа явуулж байна. Манай компани нь барилгын материалын бэлдэц, замын эрдэс үйлдвэрлэх, Шохойн чулуу бутлаж тээрэмдэж замаск гэх үндсэн чиглэлтэйгээр ажиллаж байна .
- Одоогийн байдлаар нийт 25 ажилтан албан хаагчидтай, ажиллах хүчний 80 гаруй хувь нь 25-47 насны залуучууд байдаг.
- Дархан-Уул аймгийн Хонгор сумын Шийрийн хөндийт 3 га газрыг ашиглаж байна.

б) Төслийн зохион байгуулалтууд, үйлдвэрийн бүтцийн товч танилцуулга

- Шохойн чулууг тээрэмдэх үйлдвэр
- Засвар үйлчилгээний хэсэг: засварын алба, сэлбэг хэрэгслийн агуулах,
- Компаний хашаанд: Ажилчдын байр, хоолны газар
- Компаний дэд бүтэц: Усан хангамж, цахилгаан хангамж

Шохойн чулуун үйлдвэрийн технологийн бүдүүвч



Зураг №3 Шохойн чулуу замын эрдэс нунтаг үйлдвэрлэх технологийн бүдүүвч зураг



“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Зураг №4 Өнгөлгөөний замаск үйлдвэрлэх технологийн бүдүүвч

2. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛ

Үйлдвэрлэлд гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал газрын гадарга хэвлий, агаар, хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг түүх соёлын дурсгал төсөлд хэргжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг гаргаж тусгав. Мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлож, тоон ба чанарын үнэлгээ өгнө.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс цаашид төсөл хэрэгжих явцад агаарын чанар, хөрсөн бүрхэвчийн бохирдолд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах тал дээр илүү түлхүү анхаарч, хяналт тавьж ажиллах шаардлагатай. Мөн гол сөрөг нөлөөллүүдийг доорх байдлаар нэгтгэн харуулав.

Хүснэгт №2 Гол болон сөрөг нөлөөллийн үнэлгээний шалгуур ба
анхаарвал зохих асуудлууд

Байгаль орчин/нийгмийн асуудлууд	Орон нутгийн хэмжээнд байгаль орчин, нийгэмд үзүүлж буй аливаа үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний нөлөөлөл хамгийн их нөлөө үзүүлж байгаа асуудлыг хамгийн ноцтой асуудал гэж тооцно.
Байгаль орчин/нийгмийн элемент буюу нөлөөлөлд өртөж болзошгүй параметрууд	Байгалийн физик шинж чанар: Агаарын чанар, чимээ шуугиан гадаргын усны төлөв байдал, чанар хөрсний чанар, геоморфологи биологийн буюу экологийн нөөц баялаг: Усны ургамал, амьтан, ургамал амьтан, тусгай хамгаалалттай газар нутаг, дархан цаазтай амьтан ургамлын төрөл зүйл Хүний хэрэглээний үнэ цэнэ: аж үйлдвэр, зам тээвэр, хөдөө аж ахуй, орон нутгийн усны хангамж орон нутаг дахь хаягдал усны менежмент, хог хаягдлын менежмент, эрчим хүчний хэрэглээ цахилгаан эрчим хүчний хангамж Амьдралын чанар: нийгмийн үнэ цэнэ, байгалийн үзэсгэлэн эрүүл мэнд аюулгүй байдал
Хууль эрх зүйн шаардлага	Тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх арга хэлбэрийг заасан журмуудыг батлан гаргана.
Байгаль орчны нөлөөллийн далайц	Замын эрдэс нунтаглах үйлдвэрлэх явцад болон түүхий эд материалыг тээвэрлэх явцад ойр орчимд тоосжилт үүсэх нөлөөлөлтэй.

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК

БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Нөлөөлөл үүсэх газар зүйн байршил	Төсөл хэрэгжих талбай байрлаж буй газрын орчим тойронд өөр хэд хэдэн шохойн чулууны орд газар байрлаж байгаа. Мөн талбайн ойр хэд хэдэн тариалангийн талбай байна.
Нөлөөлөл үргэлжлэх хугацаа давтамж	Замын эрдэс нунтаг үйлдвэрлэл нь улирлын чанартай буюу жилд 6 сар ажиллана. Агаарт үүсэх тоосжилт нь түүхий эд материалыг тээвэрлэх явцад үүснэ. Мөн замын эрдэс нунтаг үйлдвэрлэлийн явцад тоног төхөөрөмжөөс дуу чимээ тархана. Тоосжилт болон дуу чимээ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад л тархах үргэлжлэх хугацаа богино байна.
Хүмүүст нөлөөлөх байдал	Төсөл хэрэгжих талбай нь үйлдвэрлэлийн бүс ойр орчим зайд төслийн ажилчид, малчид, газар тариаланчид амьдарч байна. Төслийн дуу чимээ, тоосжилт нь эдгээр айл өрхөд нөлөөлнө.
Нөлөөллийн эрсдэл	Болзошгүй нөлөөлөлд тус үйлдвэрийн орчмын айл өрх болон ажилчид нөлөөлнө.
Нийгэм эдийн засгийн хувьд үзүүлэх нөлөө	Тухайн орон нутгийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Ажлын байр нэмэгдэх, ажилгүйдлийн түвшин буурч, хүн амын амжиргаа дээшлэнэ. Мөн Дархан-Уул аймгийн бүтээн байгуулалтанд сайн чанарын олон улсын шаардлага хангасан дайргаар барилга байгууламж барихад дэмжлэг үзүүлнэ.
Нөхөн сэргээж болох эсэх	Ногоон байгууламж байхгүй бөгөөд цаашид ногоон байгууламжийн ургамлын төрөл зүйлийг нэмэгдүүлж ургалтыг сайжруулах хэрэгтэй.
Нөлөөллийн нийт үнэлгээ	Нөлөөлөл дунд зэрэг боловч богино хугацаагаар үргэлжлэх эрсдэлтэй. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд сахиж ажиллах шаардлагатай

Хүснэгт №3 Төслийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

№	Болзошгүй нөлөөлөл	Бүс нутгийн түвшинд	Аймгийн түвшинд	Сум буюу орон нутгийн түвшинд	Төслийн талбайн хэмжээнд	Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
1	Уур амьсгалын өөрчлөлт	0	0	0	0	

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК

БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

	Агаарын чанарын өөрчлөлт	0	0	×	×	Агаар бохирдож болзошгүй
	Чимээ шуугиан	0	0	0	×	Үйлдвэрлэлийн талбайн хэмжээнд дуу чимээ ихсэх
	Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим	0	0	0	×	Үйлдвэрлэлийн талбайд 1 ширхэг гүний худаг бохирдож болзошгүй
	Хөрсний чанар, геоморфологи	0	0	×	×	Үйлдвэрлэлийн орчим талбай үйл ажиллагаанаас улмаас хөрсөн бүрхэвч бохирдоно
2	Усны ургамал, амьтан	0	0	0	×	Үйлдвэрлэлийн талбайд ногоон байгууламжийн зорилгоор тарималжуулсан мод, өвслөг ургамлууд тоосжилтонд өртөнө.
	Эх, газрын ургамал амьтан	0	0	0	0	Ургамлын ургалт буурах эрдэлтэй
	Тусгай хамгаалалтай газар нутаг	0	0	0	0	-
	Дархан цаазтай амьтан ургамлын төрөл зүйл	0	0	0	0	-
3	Аж үйлдвэр зам тээвэр					Үйлдвэрлэлийн талбайн машины зогсоол, үйлдвэрийн талбайг цементээр хучих шаардлагатай
	Хөдөө аж ахуй	0	0	0	0	-
	Орон нутгийн усны хангамж	0	0	0	×	Үйлдвэрлэлийн талбай нь үйлдвэрлэлийн бүсэд хамаарч байгаа айл өрхийн малыг усалдаг
	Хаягдал усны менежмент	0	0	0	0	Хог хаягдлын сургалт түүнд тохирсон хог хаягдлын ангилан ялгах, хогийн цэгт тээвэрлэх
	Хатуу хог хаягдлын менежмент	0	×	×	×	Ахуйн хог хаягдал доорх цэг хаяж төвлөрсөн хогийн цэгт НААҮГ-тай байгуулсан гэрээний дагуу хогийн цэгт хаях
	Эрчим хүчний хэрэглээ, хангамж	0	0	×	×	-

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

4	Нийгэм-эдийн засгийн байдал	+	+	+	+	Ажлын байр, орлого нэмэгдэнэ
	Археологи, палеонтологи	○	○	○	○	-
	Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал	○	○	○	×	Ажилчид тоосжилтой болон дуу чимээтэй орчинд ажиллаж чих дүлийрэх, уушигний өвчлөл тусах магадлалтай

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн үйлдвэрлэлээс байгаль орчинд учруулах болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах үндэслэл болдог.

Бид энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартуудын дагуу төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх болзошгүй болон голлох сөрөг нөлөөллийг бууруулахын тулд авах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгө зардлуудыг тооцон гаргасан.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг компанийн удирдлага тухайн жилийн үйл ажиллагааныхаа зардалд тусган төлөвлөж зарцуулж байх нь зүйтэй. Бидний боловсруулсан байгаль хамгаалах төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах боломж бүрдэхээс гадна төслийн хэрэгжих чадварыг дээшлүүлж байна.

3.1 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрлэлийн хашаанаас 30 метрт талбайд 1100 ширхэг агч болон бургас модны талбай бэлдэж, модны нүхийг бэлтгэн модыг тарьж усалгааг хийж ургуулсан болно. Ашиглахгүй талбайн хөрсөнд олон настын зүлэгний үр тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН




Зураг №5 Шохойн чулууг бутлах тээрэмдэх үйлдвэрийн тойм зураг



Зураг №6 Үйлдвэрлэлийн Google map.c авсан тойм зураг

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН



Зураг №7-8 Үйлдвэрийн хашаанаас 30 метр зайдхашаа татаж мод тарих талбай бэлтгэсэн байдал



Зураг №9-10 Талбайд мод тарихаар хөрс болон модны нүхээ бэлтгэж байгаа байдал

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН



Зураг №11-12 2-3 настай модны суулгац



Зураг №13-14 Модны суулгацаа тарихаас өмнө бордоо хийж байна.

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН



Зураг №15-16 Модоо тариад намрын цээг усалгааг хийж байна. /гадаа агаарын температур +5°C/



Зураг №19-20 7.29 нд модны суулгац бүрэн ургасан байдал



Зураг №30 Ургасан байдал

3.2 ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлын хэмжээг бууруулах нь үйлдвэрлэлийн нэг хэсэг юм. Хог хаягдлыг устгах чиглэлээр стандартад нийцэхийн тулд дахин ашиглах, боловсруулан ашиглах үйл явцыг хэрэгжүүлэх нь нэн тэргүүн чухал байна. Хог хаягдлыг ангилан ялгах тээвэрлэх, хогийн цэгт хүргэх:

ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛАХ САНААЧИЛГУУД:

- Үйлдвэрлэлийн явцад сав, баглаа боодлыг (жишээ нь хуванцар сав) устгах замаар хог хаягдлыг багасгах
- Үйлдвэрлэлийн эргэн тойронд байгаа хог хаягдлыг багасгах, цэвэрлэх, түүх, хогийн цэг рүү тээвэрлэх
- Ахуйн хог хаягдлыг бууруулах, боловсруулан дахин ашиглах зэрэгт чиглэгдсэн ажилчдад мэдлэг олгох кампанит ажлыг хэрэгжүүлэх

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Хүснэгт №4 Хог хаягдлын тухай сургалтын төлөвлөгөө

№	Нэр	Хамрагдах хүрээ	Хичээл цаг	Хичээл заах багшийн нэр
1	Энгийн хог хаягдал ба аюултай хог хаягдлын тухай ойлголт	Нийт ажилчид	1 1 1	Байгаль орчны ажилтан
2	Хог хаягдлын ангилал	Оффис ажилчид		
3	Хог хаягдлыг багасгах алхам хийх	Нийт ажилчид		
4	Хог хаягдалтай холбоотой зөрчлын тухай хуулиас танилцуулах	Нийт ажилчид		
		Нийт	3	

Хог хаягдлын ангилал

Хог хаягдлыг төлөв байдлаар нь:

- **Хатуу хог хаягдал:** орон сууц, худалдаа үйлчилгээ болон аж үйлдвэрийн хатуу төлөвт байх хог хаягдал (хуванцар, шил, лааз, цаас, хаягдал төмөр, бусад)
- **Шингэн хог хаягдал:** шингэн төлөвт байх хаягдал (угаалга болон химийн бодис, тос, цөөрөм, үйлдвэрлэл болон бусад эх үүсвэрийн бохир ус)

Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөр нь:

- Энгийн хог хаягдал
- Аюултай хог хаягдал

Хатуу хог хаягдал, түүний төрөл

- ✓ Хүнсний хог хаягдал
- ✓ Ахуйн хог хаягдал
- ✓ Үнс ба үлдэгдэл
- ✓ Барилгын хог хаягдал
- ✓ Цэвэрлэх байгууламжийн хаягдал
- ✓ Хөдөө аж ахуйн хаягдал
- ✓ Аюултай хог хаягдал



“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН



Зураг №31 Үйлдвэрийн хашаанаас 500 метр хог хаягдлыг түүж ачиж хаясан.



Зураг №32-33 Замын хажууд хогийн хаясан байсан түүж ачиж байна

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН



Зураг №33-34 Тархсан хог хаягдалыг түүж байна



Зураг №35-36 Түүсэн хогоо хогийн цэг рүү тээвэрлэж байна.

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН



Зураг №37-38 Эх байгалиа хайрлацгаая гэсэн санамж байршуулсан.

3.3 СӨРӨГ НӨЛӨӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт №5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга замын авах арга хэмжээ

№	Үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	Хамрах хүрээ	Тоо, хэмжээ	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Үйлдвэрлэлийн талбайд олон тооны том оврын машин зорчих ба тэдгээрээс агаарт их хэмжээний тоосжилт үүсэх	Ашиглалтын талбай дотор	3га	Төсөл хээгжих талбайн автомашины зогсоол болон автозамын хэсгүүдийг хатуу хучилттай болгох, засвар үйлчилгээ хийх
2	Үйлдвэрт хэрэглэгдэх түүхий эд/ шохойн чулуу/ Хадгалах хураах талбайгаас салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх	Түүхий эд хадгалах хураах талбай	700 м2	Шохой хадгалах талбайд хаалт хамгаалалт хийх

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

3	Дуу чимээний болзошгүй сөрөг нөлөөлөл	Үйлдвэрлэлийн явцад ажиллах тоног төхөөрөмжүүд	4 цэгт	Дуу шуугианы хэмжилт хийж, дуу, шуугиан бүхий машин мехнаизмын ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах
4	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг тусгайлан бэлдсэн цэгт хаяагүй, тогтсон хугацаанд ачуулж, ариутгал хийгдээгүйгээс орчны агаар бохирдох	Үйлдвэрийн талбай болон ойр орчимд	2,7тн	Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях зохих шаардлага хангасан битүүмжлэлтэй хогийн цэг хийх, хогийн цэгийн тогтмол ариутгал хийх
5	Үйлдвэрлэлийн ажиллагаанд ашиглагдаг тээврийн хэрэгслүүдээс агаар орчин бохирдох	Үйл ажиллагаанд ашиглагдаг тээврийн хээгсэл	3	Тээврийн хэрэгслүүдийг тогтмол үзлэг оношлогоонд хамруулах, утаанд хяналт тавьж ажиллах засвар үйлчилгээг тогтмол хийх
6	Шатах тослох материал асгарснаас хөрсөн бүрхэвч бохирдох	Засварын газар болон машины зогсоолын талбай	Машины зогсоол оролцоогоор талбай	Шатахуун түгээх цэгийн ойр орчмын талбайг болон автомашины зогсоолын талбайг бүхэлд нь хатуу хучилттай болгох Борооны ус зайлуулагчтай байх
7	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлаас хөрсөн бүрхэвч бохирдох	Үйлдвэрийн талбай	1	Хуурай хог хаягдал хаях цэгийн өнгөн хөрсийг хуулж 10-20 см зузаан бетонон хучилт хийж ус нэвчихгүй

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

				болгох, салхиар дамжин хийсэхгүй битүүмжлэн хийх, ангилан ялгаж хийх Тухай бүрд нь хогоо холбогдох байгууллагаар тээвэрлүүлэх
8	Газрын гадарга механик эвдрэлд орж үржил шимгүй болох	Үйлдвэрийн талбайд	2000м2	Барилга байгууламж, зам талбайгаас бусад талбайн хөрсийг тэгшилж бэлтгэх, шимт хөрсөөр хучих
9	ХАБЭА-н дүрэм, журмыг биелүүлээгүйн улмаас байгаль орчинд хохирол учруулах	Үйлдвэрийн ажилчид	нийт	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, мэдээллийг хийх

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаварыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

3.4 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНОО ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Байгаль хамгаалах ажлын талаар:


- Үйлдвэрийн ажилчдын ажиллах нөхцөл байдлыг хангах, байнга хяналт шалгалт хийх.
- Хог хаягдлыг удаан хугацаагаар хадгалахгүй байх, гэрээний дагуу хугацаанд нь ачуулах.
- Үйлдвэрийн эргэн тойронд хог хаягдлыг түүх ачих ажлыг эхлүүлэх

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

- Агаарын бохирдол болон бусад үзүүлэлтүүдийн шинжилгээг жилд 1 удаа байнга авч шинжлүүлэх. Ялангуяа тоос, дуу чимээ гэх мэт үзүүлэлтүүдийг нарийн тодорхойлуулах.
- Тос, тослох материалыг хөрсөнд нэвчихээр ил задгай хаяхгүй байх . Техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, тогтмол хяналт шалгалт хийх.
- Ургамалжуулж бут сөөг тарихдаа химийн гаралтай бодис бордоо хэрэглэхээс аль болох татгалзах.
- Ургамалжуулах зүлэгжүүлэхдээ мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөгөөг авч ажиллах.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг хийж гүйцэтгэн ажилласан болно.
- Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар тус тайлангийн бүлгүүдэд тусгасан заалт зөвлөмжүүдийг биелүүлж ажиллах арга хэмжээг авч ажилласан.

ҮЙЛДВЭРИЙН ОРЧИНД ДАХЬ ХЯНАЛТЫН ЦЭГҮҮД

1. агаарын бохирдлыг хянах 2 цэг /A, B /
2. хөрсний элэгдэл эвдрэл, талхагдал хянах 3 цэг /C, D, F/
3. 24 цагийн нийт тоосны хэмжилт хийлгэх



Зураг №39хяналтын цэгийн байдал

3.5 ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Компани нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх ажилласан.

1. Агаарын бохирдол

- Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлт: Ажлын байрны агаар дахь тоосжилт болон бусад үзүүлэлтүүд
- Хяналт шинжилгээний төрөл, хэлбэр: Сорьц авч шинжилгээ хийх
- Байршил: төслийн талбай орчмын цэгүүдээс

2. Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол

- Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлт-Хөрсний геохимийн үзүүлэлт, бохирдолт
- Хяналт шинжилгээний төрөл, хэлбэр


Ашиглалтын хугацаанд хөрсний геохимийн үзүүлэлтийг шинжлүүлсэн байна.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дараалал

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН



Зураг № 40 БОШ-ий хяналт шинжилгээ хийх дараалал



Зураг №41-42 Агаарын шинжилгээг авч байна

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН



Зураг №43-44 Үйлдвэрийн орчинд Хөрсний хэмжилт хийж буй хэсэг

Орчны шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд

2022 он



2023 он



2024 он



2025 он



Агаарын хяналт шинжилгээний харьцуулалт /PM2.5мкг/м3/

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

№	Он	Нийт тоос мкг/м ³	PM10 тоосонцор мкг/м ³	PM2.5 тоосонцор мкг/м ³
	Стандарт хэмжээ			
	MNS4585:2016	150	100	50
1	2022 он	75	75	48
2	2023 он	76	75	50
3	2024 он	89	85	78
4	2025 он	139	104	62

Шинжилгээний дүнгээс харахад PM2.5 тоосонцор 1.6 дахин их гарсан нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас бус гадны хойд зүгт байсан компаний тоосжилтоос хамаарч их гарсан гэж үзэж байгаа болно. Шинжилгээний бусад үзүүлэлтүүд стандарт хэмжээнээс давсан тохиолдолгүй байна.

Хүснэгт №7 Хөрсний химийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	2022 он	2023 он	2024 он	2025 он
1	Хөрсний ялзмаг	1.0	0.6	1.12	1.24
2	Нитрат	24.2	24.3	8.3	17.8
3	Сульфат /SO ₄ /	55.0	55.7	57.1	37.0
4	Аммони /NH ₄ /	22.5	22.7	11.9	20.0
5	Фосфор /P ₂ O ₃ /	2.1	2.0	2.4	3.6
6	Ph	7.5	7.6	7.47	8.12
7	EC	57.0	58.4	67.8	201.9

Хөрсний шинжилгээний дүнгээс харахд 2022-2025 онд стандарт хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлтгүй байна.

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Хүснэгт №8 Байгаль орчныг тухайн жилд байгаль хамгаалах менежмент төлөвлөгөөний төсвийн зардлын биелэлт.

№	Хэрэгжүүлэх ажил	Тусгасан Зардал мян, төг	Зардлын биелэлт /мян.төг/
1. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал			
1.1	Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга замын талаар авах арга хэмжээ, зөвлөмж гаргах	700.0	700.0
1.2	Дүйцүүлэни хамгаалах ажил зохион байгуулах	1000.0	1000.0
2. Ногоон байгууламж-орчны тохижилт-цэцэрлэгжүүлэлт нэмэгдүүлэх арга хэмжээний ажлын зардал			
2.1	Төслийн бүс дотор зүлэгжүүлэлт хийн, мод бут тарьж тохижуулах	2650.0	3000.0
2.2	Дархан-Уул аймгийн БОАЖГ, УЦУОШТ хамтран ногоон байгууламж байгуулах, мод бут, байгаль хамгаалах сургалт зохион байгуулах олон нийтийн арга хэмжээнд оролцох /нийгмийн хариуцлагын хүрээнд/		
3. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан зардал			
3.1	Санамсар болгоомжгүй байдлаас үүдэн осол эндэгдэл гаргах	150.0	150.0
4. Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгасан зардал			
4.1	НААҮГ-тай гэрээ байгуулан үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлыг тогтмол ачуулж, орчноо байнга цэвэр байлгах /	680.0	650.0
5. Орчны шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын зардал			
5.1	Хөрсний эвдрэл, бохирдол	450	1500.0
5.2	Агаар бохирдлоос сэргийлэх	400	
5.3	Усны шинжилгээг хийлгэх	500	
6. Удирдлагын зардал /Дүрэм , журам , төлөвлөгөөний шинэчлэл/			
6.1	Үйл ажиллагаа явуулж байгаа чиглэлтэй холбоотой хууль дүрэм журамыг танилцуулах ажиллагааг нийт ажилчдын дунд зохион байгуулах	0.0	0.0
6.2	Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй бусад зардал	150.0	150.0
Нийт зардал		6850.0	7100.0

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

4. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХЭД

Манай компаний байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан мөн тухай онд төлөвлөсөн менежментийн төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаж байгаа хэсгүүдэд хийгдсэн байгаль орчныг хамгаалах ажил болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийг дараах байдлаар дүгнэж байна.

2025 онд хийсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг дор дурьдаж байна.

Үүнд:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийг нэмэх болон тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 1500ш мод тарихаас манай компани нь 1100 гаруй ширхэг бургас болон агч модыг тарьсан.
- Компаний үйлдвэрийн хашаанаас 30метр орчим зайд агаарын тоосжилтийг намжаах, түгээхээс сэргийлж тухайн газрыг хашаалан мод тарьж, усалж ургуулсан болно.
- Үйлдвэрийн хашаанаас 500метр газар доторх зам дагуух хог хаягдлыг түүж, тээвэрлэн хогийн цэгт хаясан. Хог хаяхгүй байх талаар санамж бичиж Дархан-Шарын гол автозам дагуу компаний ойролцоо 50 метрт байршуулсан.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоох, зөвлөх үйлчилгээний тайлан үндэслэн зардлын хэмжээг төсөвлөж гүйцэтгэсэн болно Үүнд: Хонгор сумын хог тээврийн хэсэгт граш дээврийн ажилд оролцсон.
- Байгаль орчны менежментийн хүрээнд хяналтын цэгүүдийг тогтоож хагас жилд нэг удаа дээжлэлт хийж байх тогтсон цэгүүдтэй болсон. Үүнд: Агаар, хөрсний шинжилгээг Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвийн лабораториор хийсэн болно. Шинжилгээний дүнгээс харахад PM2.5 тоосонцор 1.7 дахин их гарсан нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас бус гадны хойд зүгт байсан компани болон том машины хөдөлгөөн ихтэй

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

эрчимээс хамаарч их гарсан гэж үзэж байгаа болно. Шинжилгээний бусад үзүүлэлтүүд стандарт хэмжээнээс давсан тохиолдолгүй байна.

- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулсан ба дүгнэлтээр гарсан ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Эцэст нь дүгнэхэд Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө болон байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг манай компани нь 98%-ийн биелэлттэй хийж гүйцэтгэсэн гэж дүгнээд цаашид БОННУ-д тусгагдсаны дагуу хугацаанд нь тайлагнаж дүгнүүлэн ажиллах болно.

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Хавсралт №1

0011022


БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар . БУ37-190/23

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” Монгол Улсын хуулийг үндэслэн Дархан-Уул аймаг/нийслэлийн Хонгор сум/дүүргийн “Дархан-Эрдэс шохойт шийр” ХХК -д 1911017100 4264959 /улсын бүртгэлийн дугаар/ /регистрийн дугаар/ БА-2 1 заалтын дагуу

..... ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2023 . оны . 03 . -р сарын . 28 . -ны өдрөөс таван жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД  **Ц.ДАВААСҮРЭН**

2023 . он . 03 . сар . 28 . өдөр
Улаанбаатар хот

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Хавсралт №2

5046393478 тоот дансанд цэцэрлэгжүүлэлтийн суулгацын үнэ, тарилтын хөлсийг шилжүүлнэ.

Мод бут тарих

Хавсралт-1



№	Таримлын нэр	Модны өндөр, см	Тоо, ширхэгээр	Нэг бүрийн үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг
1.	Улиас	120-150	180	5000	900000
2.	Агч	120-150	180	5000	900000
3.	Нарс	60-80	1327	65000	86250000
4.	Нүх ухах	-	1687	3000	5061000
5.	Тарилт хийх	-	1687	3000	5061000
6.	Зөвлөх	-	-	-	1823000
Нийт дүн					100 000 000

“Дархан Эрдэс Шохойт Шийр” ХХК компани
захирагч *Э. Энхсайхан*
Утас: 99084352
РД: 4264959

“Батбадрах Дэлгэр” ХХК
захирал: *Баттөмөр*
Утас: 99068791
РД: 4260813

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР”ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Хавсралт №3

Мэдээ бүртгэсэн/эмгэсэн/баталсан тухай		
№	Тайлбарын нэр	Тайлбарын утга
1.	Мэдээний төлөө байдал	баталсан
2.	Мэдээ хянаж хэрэглэгчийн нэр	БОНУАӨР - Гялболд
3.	Мэдээ хувиарласан огноо, кугацаа	2025-02-03 13:33:35
4.	Хувиргалтын тухай тэмдэглэл	
5.	Мэдээ хянасан тухай тэмдэглэл	БОННУ тайлан 2022 онд батлагдсан, Дархан-Уул аймгийн ажилын хэсэг 2024 оны БОМТ-ийн тайланг 95.5 үнэлсэн, 2025 оны БОМТ-ийн зардал 58000000 төгрөгөөр төсөвлөгдөж, 2900000 төгрөг байршуулсан, 100000 ш мод тариалж, 2025 онд Увсгай сумын 1-р багийн эзэсн газарт 1500 ширхэг мод тарих үргүүлж, Үүнд: 1. Бургас мод-600 ш, 2. Алч мод-500ш, 3. Хайлзас мод-400 ш
6.	Мэдээ хянасан огноо, кугацаа	2025-05-19 12:59:04
7.	Мэдээ хянасан хэрэглэгчийн нэр	БОНУАӨР - Гялболд
8.	Хянасан ОР код	
9.	Мэдээ баталсан огноо, кугацаа	2025-05-21 16:36:23
10.	Мэдээ баталсан хэрэглэгчийн нэр	БОНУАӨР-ны ИСОСНГЗар - Энхмөнх
11.	Баталсан ОР код	

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Хавсралт №4

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ-ийн байр
Утас: 7037-3783, 70374161
E-mail: darkhan-tsaguur@yahoo.com



ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2025/3-50
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “дэшш” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Ө.Алтанзул, БОШЛ-ийн агаарын химийн ахлах инженер
Сорьцын тоо, төрөл : 2 цэг, хөрсний химийн шинжилгээ
Сорьц авсан огноо : 2025.10.23
Шинжилсэн огноо : 2025.11.01-15
Хуудасны тоо : 3/2

№	Шинжилгээний аргын стандарт	Хөрсний химийн шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 3297:2019 ЗДХ	Тодорхойлсон агууламж	
					3060251001	3060251002
1	MNS3310:91	Хөрсний ялзмаг	%		0.95	1.24
2		Нитрат, NO ₃	мг/кг	130	22.9	17.8
3		Сульфат, SO ₄	мг/кг	160	48.7	37.0
4		Аммони, NH ₄	мг/кг		31.9	20.0
5		Фосфор, P ₂ O ₅	мг/кг		4.1	3.6
6		РН			8.95	8.12
7		ЕС		µS/cm		412.0

Товчилсон үг: ЗДХ - зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Дээжийн код: 3060251001- Үйлдвэрийн орчин
3060251002- Үйлдвэрийн орчноос 100м зайд

Тайлбар:

- Хөрсний дээжийг диагоналийн арга ашиглан авч анхан шатны боловсруулт хийн шинжилгээний ажилд бэлтгэсэн.
- Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS3297:2019 стандарт дахь хөрсний эрүүл ахуйн шаардлагын химийн үзүүлэлтээр нитрат /NO₃/, сульфат /SO₄/-ын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛ-ИЙН УСНЫ ХИМИЙН АХЛАХ
ИНЖЕНЕР
ХЯНАН, БАТАЛГААЖУУЛСАН:
БОШЛ-ИЙН ХИМИЙН ТЕХНОЛОГИЧ
ИНЖЕНЕР



Г.АНХМАА

Э.САЙНЗАЯА

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Хавсралт №5

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ



Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ-ийн байр
Утас: 7037-3783, 70374161
E-mail: darkhan-tsaquur@yahoo.com

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2025/1-53-1
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “ДЭШШ” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Г.Анхмаа, БОШЛ-ийн агаарын химийн ахлах инженер
Сорьцын тоо, төрөл : 2 цэг, агаарын бохирдлын шинжилгээ
Сорьц авсан огноо : 2025.10.23
Шинжилсэн огноо : 2025.10.24
Хуудасны тоо : 1/3

№	Шинжилгээний аргачлал	Агаарын шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS4585: 2025 1 удаагийн сорьцын ХА	Хэмжилт хийсэн цэг	
					20 минутын сорьцын дундаж агууламж /давтамж	
					1060251001	1060251002
1	MNS 0017-2-5-12:2021	Хүхэрлэг хий /SO ₂ /	мкг/м ³	450	12	7
2	MNS 0017-2-5-11:2021	Азотын давхар исэл /NO ₂ /	мкг/м ³	200	40	29
3	MNS4048-88	Нийт тоосонцор /20 мин/	мкг/м ³	500	120	77

Товчилсон үг: ХА-Хүлцэх агууламж
Сорьцын код: 1060251001- Үйлдвэрлэлийн орчин
1060251002- Үйлдвэрлэлийн орчноос 100м зайд

Тайлбар:

- 1) Тухайн сорьц авах, хэмжилт хийх хугацааны цаг агаарын нөхцөл: Агаарын чийгшил 50-55%, агаарын температур 3.5-5.0 градус хүйтэн, салхи баруун өмнөөс 2 м/с хурдтай байсан.
- 2) Агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламж агаарын чанарын MNS4585:2025 стандартын 1 удаагийн сорьцын дундаж ХА-аас давсан бохирдолгүй байна.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛ-ИЙН АГААРЫН ХИМИЙН АХЛАХ
ИНЖЕНЕР
ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
БОШЛ-ИЙН ХИМИЙН ТЕХНОЛОГИЧ
ИНЖЕНЕР



Ө.АЛТАНЗУЛ
Э.САЙНЗАЯА

“ДАРХАН ЭРДЭСТ ШОХОЙТ ШИИР” ХХК БОМТ-ий ТАЙЛАН -2025 ОН

Хавсралт №6

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ



Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ-ийн байр
Утас: 7037-3783, 70374161
E-mail: darkhan-tsaquur@yahoo.com

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2025/1-53-2
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “ДЭШШ” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Г. Анхмаа, БОШЛ-ийн ахлах шинжээч
Сорьцын тоо, төрөл : 1 цэг, агаарын бохирдлын шинжилгээ
Сорьц авсан огноо : 2025.10.23
Шинжилсэн огноо : 2025.10.24
Хуудасны тоо : 1/3

№	Шинжилгээний аргачлал	Агаарын шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS4585:2025 стандартын 24 цагийн ХА	Хэмжилт хийсэн цэг
					24 цагийн дундаж агууламж
1	MNS4048-88	Нийт тоос /TSP/	мкг/м ³	150	139
		PM10 тоосонцор	мкг/м ³	100	104
		PM2.5 тоосонцор	мкг/м ³	37.5	62

Товчилсон үг: ХА-хүлцэх агууламж,
Сорьцын код: 1060250603-Үйлдвэрлэлийн орчин
Тайлбар:

- 1) Тухайн сорьц авах, хэмжилт хийх хугацааны цаг агаарын нөхцөл: Агаарын чийгшил 62%, агаарын температур 5.1 градус хүйтэн байсан.
- 2) Агаар дахь PM10 тоосонцор, PM2.5 тоосонцор, нийт тоосны хэмжилтийг 24 цагаар хэмжсэн.
- 3) Агаарын чанарын MNS4585:2025 стандартын 24 цагийн ХА-аас PM10 тоосонцор 1.1 дахин, PM2.5 тоосонцор 1.7 дахин давсан бохирдолтой байна.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛ-ИЙН АГААРЫН ХИМИЙН АХЛАХ
ИНЖЕНЕР
ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
БОШЛ-ИЙН ХИМИЙН ТЕХНОЛОГИЧ
ИНЖЕНЕР



Ө.АЛТАНЗУЛ
Э.САЙНЗАЯА